

A SURVEY OF THE FACTORS INFLUENCING INDIVIDUAL INVESTORS' INVESTMENT DECISION MAKING IN THE MONGALIAN CAPITAL MARKET

Batjargal Nadmid^I, Buyannemekhnyam Badnaavanchin^{II}

Abstract: This study analyzed and evaluated the influence of various factors on individual investment decision-making, including personal, socio-economic, market, financial, and accounting information, as well as company operations and characteristics. The factors affecting individual investments were selected from indicators studied in similar research, with significant overlap, and primary data was collected and processed using research methods. The findings indicate that financial and accounting information plays a predominant role in shaping individual investment decisions.

Keywords: Self image, accounting information, advocate recommendation, personal financial needs

ХУВЬ ХҮНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАЛТАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Энэхүү судалгааны ажлаар хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хувь хүний, нийгэм эдийн засгийн, зах зээлийн, санхүү, бүртгэлийн мэдээлэл, компанийн үйл ажиллагаа, онцлог зэрэг хүчин зүйлийн үзүүлэх нөлөөллийг шинжилж, үнэлгээ өгсөн. Хувь хүний хөрөнгө оруулалтад нөлөөлөх хүчин зүйлсийг ижил төстэй судалгааны ажлуудад судлагдсан үзүүлэлтүүдээс илүү олон давхцалтай байсныг сонгон анхдагч мэдээллийг судалгааны аргаар цуглуулж, боловсруулсан. Судалгааны үр дүнгээс харахад хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад санхүү, бүртгэлийн мэдээлэл голлох үр нөлөөтэй гэж үзэж болохоор байна.

Түлхүүр үгс: хувийн үзэл бодол, бүртгэлийн мэдээлэл, зөвлөмж, хувийн санхүүгийн хэрэгцээ

^I Business School, National University of Mongolia, (E-mail): batjargal_nadmid@num.edu.mn

^{II} Business School, National University of Mongolia, (E-mail): 21m1num0848@stud.num.edu.mn

I. ОРШИЛ

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжин, бага, их хувьчлалын үр дүнд хөрөнгө эзэмших эрхийн асуудал чөлөөтэй болоод 30 гаруй жил болж байгаа ч 2004 оноос л олон нийт хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлтийн талаарх нээлттэй мэдээллийг авах боломжтой болсон. Хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, хөрөнгөө өсгөх зорилгоор тодорхой нэг хөрөнгөд мөнгөө байршуулахыг хэлдэг. Хөрөнгө оруулагчид зорилгодоо хүрч хөрөнгийнхөө үнэ цэнийг өсгөн, ашиг олох боломжтой байдаг ч хөрөнгө оруулалт нь ашиггүй болж, хөрөнгө нь үнэ цэнээ алдах тохиолдол ч цөөнгүй бий (Монгол банк). Иймд хөрөнгийн зах зээлийн голлох тоглогчид болон санхүүгийн шинжээчид хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн суурь шинжилгээ, техникийн шинжилгээ болон хувийн дүгнэлтдээ тулгуурладаг.

Хөрөнгө оруулагч хэдий мэдээлэл, судалгаатай, хөрөнгө оруулалтынхаа талаар тодорхой нарийн шинжилсэн байсан ч ирээдүйн алдагдлаас айж, заримдаа рационал бус үйлдэл гаргах тохиолдол гарч байдаг (Adhikari, 2020). Сэтгэл зүйн эдийн засагчдын үзэж байгаагаар шийдвэр гаргах нөхцөл байдал төвөгтэй, тодорхой бус байх үед рационал бус шийдвэр гаргах хандлагатай болдог байна. Хувь хөрөнгө оруулагчдын энэхүү өөр өөр зан төлөв нь хөрөнгө оруулагчдын рационал байдалд нөлөөлдөг олон янзын хүчин зүйлээс шалтгаалдаг тул хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх хэрэгтэй болж байгаа юм.

Хувь хөрөнгө оруулагч гэдэг нь өөрийн нэр дээр данс нээлгэж, сонирхож буй үнэт цаасаа брокеруудаар дамжуулан хамгийн ашигтай үнээр худалдан авдаг хүнийг хэлнэ (Хөрөнгийн бирж, 2014). Харин хувь хүний хөрөнгө оруулалтын зан төлөв нь өөрийн нэрийн дансаар үнийн дүн багатай үнэт цаас худалдан авах шийдвэр гаргалттай холбогддог (Shiundu, 2009).

Санхүүгийн уламжлалт онолын үүднээс авч үзэх юм бол хөрөнгө оруулагч хөрөнгө баялгаа хамгийн их байлгах санхүүгийн суурь зарчмын дагуу эрсдэл ашгийн харьцаанд тулгуурлан хөрөнгө оруулалтын стратегиа тодорхойлдог. Гэвч бодит байдал дээр хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хүлээн авах түвшин харилцан адилгүй байдаг нь хөрөнгө оруулагчийн эрсдэлд хандах хандлага, хувийн санхүүгийн хэрэгцээ, эдийн засгийн нөхцөл байдал, зах зээлийн бүтэц, компанийн үйл ажиллагаа, онцлог зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байдаг. Үүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх сүүлийн үеийн судалгаанууд илүү сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлийн буюу бүхэлдээ зан төлөвийн тодорхой нөлөөллийн талаар судлагдах болсон байна.

Энэхүү судалгааны ажлаар хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хамгийн их нөлөөлж болохуйц хүчин зүйлс болох хувь хүний үзэл бодол, хандлага, нийгэм эдийн засгийн, зах зээлийн, санхүү, бүртгэлийн мэдээлэл болон бусдын санал зөвлөмж,

компанийн үйл ажиллагаа, онцлог зэрэг хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгаа талаар анкетын асуулга боловсруулан 101 (түүврийн хэмжээг олох аргаар тооцсон) хувь хөрөнгө оруулагчдаас авсан судалгааны үр дүнд хувь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж, дүгнэлээ.

Судалгааны ажлын хоёрдугаар хэсэгт хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судлагдсан байдал, дараагийн хэсэгт судалгааны арга зүйн талаар авч үзнэ. Дөрөвдүгээр хэсэгт судалгааны асуулгын үр дүнгийн шинжилгээний талаар эцэст нь дүгнэлт, зөвлөмж гаргана.

II. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судлагдсан ажлуудыг тоймлон авч үзвэл ерөнхийдөө уламжлалт санхүүгийн онолоос эхлээд зан төлөвийн санхүүгийн онолд тулгуурлан судлагдаж байна.

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалттай холбоотой уламжлалт санхүүгийн онолын хувьд ерөнхийдөө дараах чиглэлээр судлагдаж байна. Үүнд:

1. Хүлээгдэж буй ханамжийн онол (Expected Utility Theory)
2. Багцын онол (Portfolio Theory)
3. Үр ашигт зах зээлийн таамаглал (Efficient Market Hypothesis)-ын арга, хандлага орно.

Харин зан төлөвийн санхүүгийн онолын хүрээнд судлагдсан ажлуудыг тоймлон авч үзвэл дараах чиглэлээр судлагдаж байна. Үүнд:

1. Харамсах онол (Regret theory)
2. Ухамсарт (хэсэгчилсэн) тооцооны онол (Theory of mental accounting)
3. Хэт төлөвийн / Хохирлоос зайлсхийх онол (Prospect/Loss-aversion theory)
4. Хүлээлтээс илүү / хүлээлтээс доогуур хариу үйлдлийн онол (Over/Under reacting theory)
5. Хэт итгэлтэй байдлын онол (Overconfidence theory) орж байна.

Masomi ба Ghayekhloo (2011) нарын судалгаанд дурдсанаар, уламжлалт санхүүгийн эдийн засгийн онолын дагуу шийдвэр гаргадаг хөрөнгө оруулагчид ухаалаг, ашиг орлогоо хамгийн их байлгах боломжтой гэж үзсэн (Masomi & Ghayekhloo, 2011). Үүнийг Chandra ба Kumar (2008) нарын судалгаа баталсан бөгөөд хөрөнгө оруулагчийн ухаалаг байдал нь өөрт ашигтай шийдвэр гаргах, бодитой үр дүнг гаргахад оршино гэжээ (Chandra & Kumar, 2008). Мөн Somil (2007) хувь хүн өөрийн ашиг сонирхлыг дээд зэргээр хангах зарчимд тулгуурлан санхүүгийн онолын дагуу рационал шийдвэр гаргадаг ч хөрөнгө оруулагчид орчин тойрноо төгс гэж үзэх нь бодитой бус болохыг дурдсан (Somil, 2007).

Уламжлалт санхүүгийн онолын хүрээнд “Хөрөнгийн зах зээл төгс үр ашигтай байх ёстой” гэж үздэг хэдий ч ихэнх хөрөнгийн зах зээл үр ашиггүй нөхцөлд ажилладаг учраас ухаалаг шийдвэр гаргах боломж хязгаарлагдмал болохыг Mahmood, Ahmad, Khan, Anjum (2011) нарын судалгаагаар баталсан байдаг (Mahmood, et al., 2011). Ийнхүү тэдний 1980-аад онд хийгдсэн дийлэнх судалгаа “Үр ашигт зах зээлийн таамаглал”-ыг няцаасан. Харин Simon (1986) хөрөнгө оруулагчдын мэдээлэл боловсруулах чадварын хязгаарлагдмал байдлаас үүдэн ухаалаг шийдвэр гаргах боломжгүй гэж үзсэн нь зах зээлийн үр ашгаас илүү хөрөнгө оруулагчийн зан төлөвтэй холбогдож байгаа юм (Simon, 1986). Мөн Tversky ба Kahneman (1974) нарын судалгаагаар шийдвэр гаргах үйл явц төгс ухаалаг биш, харин шийдвэр гаргагчид мэдээллийг сонгон авч, хялбаршуулан дүгнэх хандлагатай байдгийг дурджээ (Tversky & Kahneman, 1974). Үүнтэй холбоотойгоор зан төлөвийн санхүүгийн онол нь хөрөнгө оруулагчдын зан төлөвийг сэтгэл зүйн зарчмаар тайлбарладаг бөгөөд хүмүүс хувьцаа худалдан авах, зарах шийдвэр гаргахад сэтгэл зүйн хүчин зүйлс чухал нөлөөтэйг харуулсан (Al-Tamimi, 2005).

Ийнхүү дээрх судлаачид уламжлалт болон зан төлөвийн санхүүгийн онолын хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтын талаар судалсан байгаа бол хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судлаачид өөр өөрсдийн улсын жишээн дээр судалсаар байна.

Хувь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар бидний судалсан судалгааны ажлуудад хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хувийн үзэл бодол, бусдын санал зөвлөмж, эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн мэдээлэл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, хувийн санхүүгийн хэрэгцээ зэрэг хүчин зүйлс голлох нөлөөтэйг тодорхойлсон байна.

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын онолын үндэс нь зан төлөвийн санхүүгийн шийдвэр гаргалтын онол бөгөөд хөрөнгийн зах зээл дээрх хувь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалт үргэлж янз бүрийн мэдээллийн урсгалд өртөж байдаг. Тухайлбал, санхүүгийн тоон өгөгдөл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй санхүүгийн мэдээ, нийгмийн харилцаанаас үүдсэн санал, зөвлөмжөөс хөрөнгө оруулагчийн шийдвэр хамаардаг (Shiundu, 2009).

Энэ хэсэгт судалгааг хэрхэн зохион байгуулсан хийгээд хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлоход ашигласан арга зүйн талаар товч авч үзнэ. Судалгааны асуулгын найдвартай байдлыг Кронбахын альфа (Cronbach's Alpha) тестээр, түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй эсэхийг КМО and Bartlett's тестээр шалгасан.

Хэмжигдэхүүн x_j нь t_j болон e_j -н $x_j = t_j + e_j$, $j = \overline{1, k}$ байг. Энд e_j бүр нь t_j -ээс үл хамаарна. Мөн бүх e_j -г өөрөө өөрсдөөсөө үл хамаардаг гэж үзье. Эдгээр нөхцөлөөс дараах хоёр хэмжигдэхүүний нийлбэр тодорхойлогдоно.

$$x_0 = \sum_{j=1}^k x_k \quad (1)$$

$$t_0 = \sum_{j=1}^k t_k \quad (2)$$

Хоорондоо ялгаатай $t_i - t_j$ -н вариаци нь

$$\text{var}(t_i - t_j) = \text{var}(t_i) + \text{var}(t_j) - 2\text{cov}(t_i, t_j)$$

гэж тодорхойлогдох ба $\text{var}(t_i - t_j) \geq 0$ тул

$$\text{var}(t_i) + \text{var}(t_j) \geq 2\text{cov}(t_i, t_j) \quad (3)$$

байна. Хэрэв $i \neq j$ ба $i = \overline{1, k-1}$ бол (3)-г

$$2 \sum_{i=1}^{k-1} \sum_{i < j} \text{cov}(t_i, t_j) \leq 2(k-1) \sum_{i=1}^k \text{var}(t_i)$$

гэж бичиж болно. Цааш нь $i \neq j$ гэсэн нөхцөлөөс

$$\sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j) \geq (k-1) \sum_{i=1}^k \text{var}(t_j) \quad (4)$$

байна. Одоо (2)-н вариаци нь

$$\begin{aligned} \text{var}(t_0) &= \text{var}\left(\sum_{j=1}^k t_k\right) = \sum_{j=1}^k \text{var}(t_k) + \sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j) \geq \\ &\geq \frac{1}{k-1} \sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j) + \sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j) = \frac{k}{k-1} \sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j) \end{aligned} \quad (5)$$

гэж гарна. Таамаглалын дагуу e_j нь t_j -с үл хамаарах тул

$$\text{cov}(x_i, x_j) = \text{cov}(t_i, t_j)$$

байна. Иймд (1)-н вариаци нь

$$\text{var}(x_0) = \text{var}\left(\sum_{j=1}^k x_k\right) = \sum_{j=1}^k \text{var}(x_j) + \sum_{i \neq j} \text{cov}(x, x_j) \quad (6)$$

гэж гарна. Иймд (5)-г (6)-д харьцуулбал

$$\begin{aligned}\alpha &= \frac{\text{var}(t_0)}{\text{var}(x_0)} \geq \frac{k}{k-1} \cdot \frac{\sum_{i \neq j} \text{cov}(t_i, t_j)}{\text{var}(x_0)} \\ &= \frac{k}{k-1} \cdot \frac{\text{var}(x_0) - \sum_{j=1}^k \text{var}(x_j)}{\text{var}(x_0)} = \\ &= \frac{k}{k-1} \cdot \left(1 - \frac{\sum_{j=1}^k \text{var}(x_j)}{\text{var}(x_0)}\right)\end{aligned}$$

буюу

$$\alpha = \frac{k}{k-1} \cdot \left(1 - \frac{\sum_{j=1}^k \text{var}(x_j)}{\text{var}(x_0)}\right) \quad (7)$$

гэж олдоно. Энд α -г Cronbach's Alpha гэж нэрлэдэг. Кронбахын альфагийн тооцогдсон утгаас хамааран нийцтэй байдлыг дараах хүснэгтийн дагуу тодорхойлдог (Батжаргал.Н & Анхбаяр.Ч, 2024).

Cronbach's Alpha	Нийцтэй байдал
$\alpha \geq 0.9$	Маш сайн
$0.9 > \alpha \geq 0.8$	Сайн
$0.8 > \alpha \geq 0.7$	Хүлээн авахуйц
$0.7 > \alpha \geq 0.6$	Анхаарах
$0.6 > \alpha \geq 0.5$	Тааруухан
$0.5 > \alpha$	Нийцгүй

Хүчин зүйлийн шинжилгээ хийхэд тавигддаг дараах шаардлагыг ханган олон тооны хувьсагчдыг хамгийн их нийтлэг хүчин зүйлсээр нь ялган ангилсан. Үүнд:

- Түүврийн тоо хэмжээ их байх
- Хэт ялгаатай утга байхгүй байх
- Шинжилгээнд ашиглах хувьсагчид нь ижил төрлийн байх
- Дараалсан хэмжээст хувьсагчдыг шинжилгээнд оруулах явдал болно.

Судалгааны түүврийг сонгохдоо Монгол улсын нийт хүн амын тоонд тулгуурлан дараах хэмжигдэхүүнээр түүврийн хэмжээг тодорхойлж, түүнээс багагүй байх гэсэн шалгуур тавьсан. Эх олонлогийн шинж чанарын талаар статистик дүгнэлт гаргах үйл ажиллагааг түүвэр гэж ойлгож болно (Үндэсний статистикийн хороо).

$$n = \frac{\frac{z^2 * p(1-p)}{e^2}}{1 + \frac{z^2 * p(1-p)}{e^2 * N}} \quad (8)$$

- N- Эх олонлог-127,578
- Z- Итгэх түвшин 90%- 1.64
- e- Алдааны зөрүү- 0.1

- р- Стандарт хазайлт- 0.5
- n- Түүврийн хэмжээ- 67.2

Судалгааны санал асуулгын аргыг ашиглан анхдагч мэдээллийг Microsoft forms-оор авч, судалгааны үр дүнг биечлэн шалгаж, цуглуулсан мэдээллийг кодлон, хүснэгт, графикийн шинжилгээг хийлээ.

Анкетын асуулгыг тухайн хүний өөрийнх нь үзэл бодол, бусдын зөвлөмж, эдийн засгийн үзүүлэлт, зах зээл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, компанийн үйл ажиллагаа, онцлог, зах зээлийн мэдээлэл, хувийн санхүүгийн хэрэгцээ гэсэн долоон ангилалд багтаасан үндсэн хоёр хэсэгтэй боловсруулсан.

Нэгдүгээр хэсэг нь хөрөнгө оруулагчдын ерөнхий мэдээлэл (хувь хүний мэдээлэл), хоёрдугаар хэсэг нь хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлдөг хүчин зүйлстэй холбоотой мэдээлэл болно. Дээрх долоон ангилалд хамаарах асуултуудыг боловсруулж, эдгээр хүчин зүйлсийн нөлөөг хэр хэмжээнд хүлээн авдгийг 5 онооны Ликертын шкалаар үнэлсэн. Мэдээллийг SPSS программын тусламжтай тайлбарлаж, статистикийн дүгнэлт хийхэд ашигласан бөгөөд тайлбарлах статистик, Фридманы тест, хүчин зүйлийн шинжилгээний аргачлалуудыг ашиглалаа.

IV. ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Нийцтэй байдлын шинжилгээ

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
0.957	0.972	107

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Кронбахын альфа нь 0.957-оос дээш байгаа нь судалгааны асуулга нийцтэй болохыг илэрхийлж байна.

KMO and Bartlett's test

Kaiser-Meyer-Olkin Adequacy.	Measure of Sampling	0.842
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	7216.144
	df	2145
	Sig.	0.000

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

КМО нь хүчин зүйлийн шинжилгээ хийхэд түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй эсэхийг хэмжих ба 0.5-аас их байх ёстой гэж үздэг. Дээрхээс харахад КМО нь 0.842 буюу түүврийн хэмжээ хангалттайг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан 101 хүний 57 хувь нь эмэгтэй, 43 хувь нь эрэгтэй байсан бөгөөд 49 хувь нь 21-30 насны, 37 хувь нь бизнесийн байгууллагын, сарын 1-3 сая хүртэлх дундаж орлоготой, 64 хувь нь бүрэн дээд боловсрол эзэмшсэн, бакалаврын зэрэгтэй байснаас гадна 31 нь банк санхүүгийн мэргэжлийн хүмүүс байв.

Эдгээр хөрөнгө оруулагчдын 36 хувь нь хувьцаанд, 25 хувь нь үл хөдлөх хөрөнгө, орон сууцанд хөрөнгө оруулах сонирхолтой байгаа бол хөрөнгө оруулалтын туршлагын хувьд 45 хувь нь 1 хүртэл жилийн, хөрөнгийн зах зээл дээр эзэмшиж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээний тухайд 46 хувь нь 1 сая хүртэл, дийлэнх буюу 54 хувь нь цалингийн эх үүсвэрээр дунд хугацаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байна.

Мөн хөрөнгө оруулалтаа хянаж, дахин сар бүр хөрөнгө оруулалт хийхийг эрмэлздэг нь 39 хувь байхад дийлэнх буюу 57 хувь нь хаа нэг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргадаг гэжээ. Ингэхдээ эмэгтэйчүүдийн хувьд компанийн жилийн тайлан, төлөвлөгөөнд илүү тулгуурлан шийдвэр гаргаж байхад эрчүүд брокерийн компанийн мэдээллийг илүү ач холбогдолтой гэж үздэг байна. Насны хувьд 20-40 насныхан компанийн жилийн тайлан төлөвлөгөөг илүү анхаарч хөрөнгө оруулах хандлагатай байгаа бол 41-ээс дээш насныхан брокерийн компани болон гэр бүл найз нөхдийнхөө мэдээлэлд тулгуурлан хөрөнгө оруулалт хийж байна.

Хөрөнгө оруулах шалтгааны хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүс бараг ялгаагүй, ашиг орлогыг хөрөнгө оруулах шалтгаан гэж үзэж байгаа ч 20 хүртэлх насны хүмүүс хүлээгдэж буй өгөөж болон хөрөнгө оруулалтын эрхийн хувийг илүүд, 21-50 насны хүмүүс ногдол ашгийн орлого, ашгийг илүү гэж үзэж байна.


Зураг 1. Хөрөнгө оруулах шалтгаан



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Хүйсийн хувьд эрэгтэй эмэгтэй хүмүүс ялгаагүй ихэвчлэн банкны салбарт хөрөнгө оруулах сонирхолтой байдгаас 20-40 насныхан илүү банкны салбарын хөрөнгө оруулалтыг 41-ээс дээш насныхан үйлчилгээний салбарын хөрөнгө оруулалтыг илүүд эрхэмлэж байна.

Зураг 2. Хувьцааны хөрөнгө оруулалт хийх сонирхолтой салбар



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Хүчин зүйлийн шинжилгээ

Хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх дараах долоон ангилал бүхий бүлэг хүчин зүйлсийн ач холбогдол, үр нөлөөг эрэмбэлж үзвэл Санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хамгийн их нөлөөлж байна.

Хүснэгт 1. Хувь хүний санхүүгийн шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлс

Бүлэг	Хамгийн нолоотой хүчин зүйл	Дундаж
Санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл	Санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сүүлийн үеийн гүйцэтгэл (компанийн хүлээгдэж буй орлого, ашиг, нэгж хувьцааны ногдол ашиг)	4.2871
Эдийн засгийн үзүүлэлт	Төв банкны бодлого, хүүгийн түвшин	4.2673
Компанийн үйл ажиллагаа, онцлог	Компанийн нэр хүнд	4.2475
Хувь хүний үзэл бодол, мэдрэмж	Хөрөнгө оруулалтын өгөөж өндөртэй үнэт цаасыг илүүд үзнэ	4.1980
Зах зээлийн мэдээлэл	Хөрөнгийн зах зээл дээрх арилжааны хэмжээ	4.1683
Бусдын зөвлөгөө мэдээлэл	Гэр бүл гишүүдийн санал зөвлөмж	4.1386
Хувийн санхүүгийн хэрэгцээ	Эрсдэл, алдагдлыг хамгийн бага байлгах	3.9802

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 2. Тодорхойлогч статистик (Descriptive Statistics)

	N	Mean	Std. Deviation
Санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сүүлийн үеийн гүйцэтгэл (компанийн хүлээгдэж буй орлого, ашиг, нэгж хувьцааны ногдол ашиг)	101	4.2871	0.75282
Орлогын тайлан болон санхүүгийн байдлын тайлангийн ашиг, санхүүгийн байдал	101	4.2871	0.79166
Төв банкны бодлого, хүүгийн түвшин	101	4.2673	0.71960
Компанийн өнгөрсөн хугацааны өгөөж, эрсдэл	101	4.2673	0.77319
Ногдол ашиг хуваарилалт, өсөлтийн чиг хандлага	101	4.2673	0.76015
Компанийн хувьцааны өнгөрсөн үеийн гүйцэтгэл	101	4.2673	0.77319
Хөрөнгө оруулагчдын хүлээгдэж буй ногдол ашиг, орлого	101	4.2574	0.75701
Санхүүгийн тайлангийн ил тод байдал	101	4.2475	0.84150
Компанийн нэр хүнд	101	4.2475	0.74035
Компанийн салбарт эзлэх байр суурь, салбарын мэдээлэл	101	4.2277	0.70542
Инфляц	101	4.2079	0.81629
Үйл ажиллагааны тайлан	101	4.2079	0.72549
Хөрөнгө оруулалтын өгөөж өндөртэй үнэт цаасыг илүүд үзэх	101	4.1980	0.70739
Компанийн ногдол ашгийн бодлого	101	4.1782	0.69851
Компанийн хэмжээ, ирээдүйн өсөлт хөгжил	101	4.1782	0.66927
Хөрөнгийн зах зээл дээрх арилжааны хэмжээ	101	4.1683	0.78828
Хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтыг эрхэмлэх	101	4.1683	0.63355
Урт хугацаанд тогтмол ашиг олох чухал	101	4.1683	0.70809
Хөрөнгийн зах зээлийн индекс, өөрчлөлтийн чиг хандлага	101	4.1485	0.66912
Гэр бүл гишүүдийн санал зөвлөмж	101	4.1386	0.73525
Компанийн жилийн тайлан, төлөвлөгөө	101	4.1089	1.06678
Хувьцааны мөнгөн гүйлгээний үзүүлэлт	101	4.1089	0.83548
Нэгж хувьцааны захиалгын үнэ	101	4.0990	0.79379
Санхүүгийн нарийвчилсан шинжилгээ хийсний дараа хөрөнгө оруулах	101	4.0990	0.68564
Ирээдүйд хувьцааны үнэ өснө гэсэн хүлээлтээр хувьцаа худалдан авахыг эрхэмлэх	101	4.0891	0.73619
ҮЦК буюу брокерийн зөвлөмж	101	4.0792	0.74409
Компанийн амьдралын мөчлөг	101	4.0792	0.65853

Зохион байгуулалт сайтай санхүүгийн зах зээл бий болгох санаачилга	101	4.0693	0.80321
Хувьцааны ханш, хэлбэлзлийн талаарх мэдээлэл	101	4.0693	0.75176
Компанийн ёс зүйн талаарх үнэлэмж	101	4.0693	0.80321
Хувьцаанд хөрөнгө оруулахад хөрөнгө оруулагчдын харгалздаг ногдол ашгийн өсөлтийн хандлага	101	4.0693	0.77791
Зохицуулалт	101	4.0594	0.86973
Брокерийн компанийн мэдээлэл	101	4.0594	1.06604
Өрсөлдөөний түвшин	101	4.0594	0.74595
Эдийн засгийн талаарх мэдрэмж	101	4.0495	0.71241
Бусад ижил төрлийн компанийн эрсдэл, өгөөж	101	4.0495	0.73995
Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт хууль, эрхзүйн орчноос хамаардаг	101	4.0396	0.83571
Тухайн хөрөнгө оруулалтад хандах хандлага, мэдрэмж (жишээ нь хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө)	101	4.0396	0.63120
Хөрөнгө оруулалтаас алдах эрсдэлийг аль болох багасгахыг хичээдэг	101	4.0396	0.70599
Компанийн удирдлагын баг /ТУЗ, гүйцэтгэх удирдлага/	101	4.0297	0.81799
Тухайн компанийн салбарын мэдээлэл нөлөөлдөг	101	4.0297	0.80567
Засгийн газрын албан тушаалтнуудын мэдэгдэл	101	4.0099	0.75492
Санхүүгийн шинжээчийн шинжилгээ санал зөвлөмж	101	4.0000	0.84853
Эрсдэл, алдагдлыг хамгийн бага байлгах	101	3.9802	0.87155
Сайн мэдэхгүй компанийнхаа хувьцааг худалдан авахгүй байх	101	3.9703	0.83013
Технологи	101	3.9703	0.80567
Компанийн нийгмийн хариуцлага	101	3.9604	0.79901
Хөрөнгө оруулалтыг тараан байршуулах хэрэгцээ	101	3.9406	0.92544
Голлох хөрөнгө оруулагчдын санал бодлыг харгалзан үзэх	101	3.9307	0.85156
Ногдол ашгийн орлогоороо хувьцаанд дахин хөрөнгө оруулах хандлага	101	3.9109	0.77587
Зах зээл дээрх алдагдлыг бууруулах шаардлага	101	3.8911	0.87064
Хөрөнгө оруулалтад эрсдэл байх нь зайлшгүй	101	3.8911	0.90444
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ	101	3.8812	0.77829
Хувьцааны үнэ өсөх үед зарах хандлага	101	3.8317	0.94941
Богино хугацаанд их ашиг олох чухал	101	3.8218	0.96329
Хувьцааны үнэ буурах үед хувьцаанд хөрөнгө оруулах	101	3.8119	0.99712

Дийлэнх хөрөнгө оруулагчдын шийдвэрийг дагах	101	3.7921	0.77868
Хурдан баяжих хүсэл	101	3.7723	0.96831
Хувьцааны бус хөрөнгө оруулалтын сонирхол	101	3.7426	0.89054
ДНБ	101	3.7327	0.93692
Валютын ханш	101	3.7030	0.90049
Хөрөнгө оруулалт хийх үед итгэл, айдас зэрэг тухайн үеийн сэтгэл санаа нөлөөлдөг	101	3.6931	0.86882
Найз нөхөд, хамт олны санал зөвлөмж	101	3.6733	0.88441
Ногдол ашгийн орлого	101	3.6634	1.32119
Зээлээр авахад хялбар байх	101	3.6634	0.98262
Хөрөнгө оруулалттай холбоотой миний шийдвэрүүд оновчтой	101	3.6535	0.82989
Хувьцааны үнэ буурах төлөвтэй үед зарах хандлагатай	101	3.6040	1.10525
Хэвлэл мэдээлэл	101	3.5941	1.05998
Санамсаргүй олж мэдсэн мэдээллийг харгалзан хөрөнгө оруулах	101	3.5743	1.00346
Сошиал мэдээлэл	101	3.5545	1.04379
Хүлээгдэж буй өгөөж болон эрхийн хувь	101	3.5446	1.36033
Богино хугацаан дах хувьцааны үнийн өсөлт	101	3.5347	1.26146
Ажилладаг компанийнхаа хувьцаанд зайлшгүй хөрөнгө оруулах	101	3.4554	0.95420
Гэр бүл болон найз нөхдийн нөлөө	101	3.3861	1.11329
Урт хугацаан дах хувьцааны үнийн өсөлт	101	3.3366	1.49851
Хөрөнгө оруулалтаас баяр хөөр, сэтгэл хөдлөл мэдрэх	101	3.2970	1.37510

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүчин зүйлийн шинжилгээний дундаж утгуудыг авч үзвэл хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйлс санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл байна. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайлангийн үзүүлэлт,
- ✓ Сүүлийн үеийн гүйцэтгэл (компанийн хүлээгдэж буй орлого, ашиг, нэгж хувьцааны ногдол ашиг)
- ✓ Орлогын тайлан болон санхүүгийн байдлын тайланд хамаарах үзүүлэлт, тухайлбал тайлангийн ашиг, санхүүгийн байдал зэрэг байна.

VI. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тухайн хүний өөрийнх нь үзэл бодол, бусдын зөвлөмж, эдийн засгийн үзүүлэлт, зах зээл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, компанийн үйл ажиллагаа, онцлог, зах зээлийн мэдээлэл, хувийн санхүүгийн хэрэгцээ гэсэн долоон ангиллаар тодорхойлсон.

Судалгааны санал асуулгыг 101 хүнээс Microsoft forms-оор авч, судалгааны үр дүнг биечлэн шалгаж, цуглуулсан мэдээллийг кодлон хүснэгт, графикийн аргаар статистикийн шинжилгээг хийлээ. Мэдээллийг SPSS программын тусламжтай тайлбарлаж, статистикийн дүгнэлт хийхэд ашигласан бөгөөд тайлбарлах статистик, Фридманы тест, хүчин зүйлийн шинжилгээний аргачлалуудыг мөн ашиглав.

Хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нөлөөлөх тухайн хүний өөрийнх нь үзэл бодол, бусдын зөвлөмж, эдийн засгийн үзүүлэлт, зах зээл, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, компанийн үйл ажиллагаа, онцлог, зах зээлийн мэдээлэл, хувийн санхүүгийн хэрэгцээ гэсэн долоон ангилал бүхий бүлэг хүчин зүйлсийн ач холбогдол, үр нөлөөг эрэмбэлж үзвэл Санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хамгийн их нөлөөлж байна. Эдгээрээс компанийн санхүүгийн тайланд хамаарах үзүүлэлт буюу компанийн санхүүгийн гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлт хувь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад хамгийн их нөлөөлдөг байна.

Ашигласан материал

- Adhikari, P. L. (2020). Factors influencing investment decisions of individual investors at Nepal stock exchange. *Management Dynamics*, 23, 1-16.
- Chandra, A., & Kumar, R. (2008). Decision making in the stock market: Incorporating psychology with finance. *Journal of Behavioral Finance*.
- Mahmood, I., Ahmad, H., Khan, Z. A., & Anjum, M. (2011). Behavioral Implications of Investors for Investments in the Stock Market. *European Journal of Social Sciences*, 20, 240-247.
- Masomi, S. R., & Ghayekhloo, S. (2011, November). Consequences of human behaviors' in Economic: the Effects of Behavioral Factors in Investment decision making at Tehran Stock Exchange. *Business and Economics Research Journal*, 234-237.
- Obamuyi, T. M. (2013). Factors influencing investment decisions in capital market: a study of individual investors in nigeria (vol. 4). *organizations and markets in emerging economies*.
- shiundu, m. v. (2009). A survey of the factors influencing investment decisions: the case of individual investors at the nse. school of business, university of nairobi.
- Simon, H. A. (1986). Rationality in Psychology. *The Journal of Business*, 59, 209-224.
- Somil, N. (2007). Investigating the Factors Affecting the Investment Decision in Residential Development. The University of Notingham.
- Tversky, A., & Kahneman, D. (1974). Judgment under Uncertainty: Heuristics and Biases. *JSTOR*, 185, 1124-1131.
- Wrightman, L. S., Cook, S. W., & Selltiz, C. (1976). Research methods in social relations.
- Батжаргал.Н, & Анхбаяр.Ч. (2024). Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг үнэлэх арга зүй. УБ хот: Хангай принтинг.
- Монгол банк. Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээл. Улаанбаатар: Монгол банк, "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр".
- Үндэсний статистикийн хороо. Түүврийн арга зүйн үндэс, хэрэглээ, ач холбогдол. УБ хот: Үндэсний статистикийн хороо.
- Хөрөнгийн бирж. (2014). Та хувьцааны дансаа нээлгэсэн үү? Хувьцааны цагаан толгой. Улаанбаатар: Хөрөнгийн бирж.